# ГЕРОНТОЛОГИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ

| Д/д | Арга хэмжээ | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хэрэгжилтийн үйл явц | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилго: Салбар дундын оролцоонд тулгуурласан настны эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тасралтгүй, чанартай, хүртээмжтэй хүргэхэд оршино.** | | | | | | | |
| **Зорилт 1. Ахмад настныг насжилтаас үүдэлтэй өвчин эмгэгээс урьдчилан сэргийлнэ.** | | | | | | | |
| БСТ 1.1.1.1 | 1. Ахмад настанд зориулсан эрүүл мэндийн боловсрол сургалт, сурталчилгаа, ухуулга нөлөөллийг тасралтгүй зохион байгуулна. | Улсын хэмжээнд 2024 онд нийт настнуудын 7,8 хувь нь мэдээлэл сургалт сурталчилгаанд хамрагдсан байна. | Улсын хэмжээний 280 000 ахмад настнуудын 8.2 хувь нь буюу 35 000 хүн хамрагдсан байна. | I-IV улирал | ЭШСА | “Насжилтын асуудлаарх үндэсний стратеги”, Геронтологийн үндэсний төвийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу ахмад настны эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, эрүүл зан үйлийг хэвшүүлэх, эрүүл идэвхтэй насжилтад чиглэсэн үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор “Эрүүл насжилтын төлөө хамтдаа” уриан дор эрүүл амьдралын насан туршийн боловсрол олгох, эрүүл амьдралын хэв маягийг дэмжих, настнуудын бие даасан хараат бус байдал, саад бэрхшээлийг даван туулах чадварыг сайжруулах сургалтыг 2025 оны эхний улиралд зохион байгуулж нийт настны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа Нийслэлийн 18 байгууллага, нийт 127 настан оролцлоо.<br>Нийслэлийн Эрүүл Мэндийн Газар, Баянзүрх дүүргийн Эрүүл Оршихуй ӨЭМТ-тэй хамтран “ Эрүүл амьдарч, урт наслая” өдөрлөг зохион байгуулж Эрүүл насжилт, Эмийн зохистой хэрэглээ сэдвээр сургалт явуулан нийт БЗД-ийн 13 хорооны ӨЭМТ, 62 ахмад настан оролцлоо.<br>✓ Сүхбаатар дүүргийн Ахмадын хөгжлийн төвд 2025 оны 4 дүгээр сарын 7-ний өдөр “Эрүүл урт насжилт”, “Эмийн зохистой хэрэглээ“ сэдвээр настнуудын насжилтад хандах сөрөг хандлагыг | |

| Д/д | Арга хэмжээ | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хэрэгжилтийн үйл явц | Биелэлт ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бууруулах, өөрийгөө эергээр хүлээн зөвшөөрөх явдлыг нэмэгдүүлэх зорилгоор сургалт зохион байгуулж нийт СБД-ийн 8,10,11,12,13 хороодын настан, зохион байгуулагч, настны асуудал хариуцсан мэргэжилтэн нийт 65 ахмад настан оролцлоо.<br>✓ 2025 оны 4 дүгээр сарын 21 - 29 нийг хүртэл Баруун бүсийн Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий, Увс аймгуудад зохион байгууллаа. Сургалтанд аймаг, сумын оршин суугч нийт 162 настан оролцсон байна. | |
| БСТ 1.1.1.2 | 2. Алслагдсан аймаг, дүүрэг, хороо, сум тосгоны настнуудад эрт илрүүлэг урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулна. | Булган, Өвөрхангай аймаг, Нийслэлийн 6 дүүрэг, хороо, сум тосгоны 1903 ахмад настан хамруулсан байна. | 6-аас доошгүй алслагдсан хороо, дүүргийн 2000 ахмад настан хамруулна. | I-IV улирал | ЭТҮА | Сэлэнгэ аймаг Мандал суманд,Бага-хангай дүүргийн ахмадын хороо Нийслэлийн 3 дүүрэг 16 хорооноос 1053 ахмад настан хамруулсан байна.<br> <br> | |

| Д/д | Арга хэмжээ | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хэрэгжилтийн үйл явц | Биелэлт ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| БСТ 1.1.1.3 | 3. Ахмадын эрүүл мэндийг дэмжих сарын хүрээнд үйл ажиллагаа зохион байгуулна. | Улсын хэмжээнд эрүүл мэндийн тэмдэглэлт өдрүүдийг ахмадын ЭМ-ийг дэмжих сарыг тэмдэглэж заншсан. | 3 төрлийн үйл ажиллагаа зохион байна. | IV улирал | ЭШСА | - | - |
| **Зорилт 2. Ахмад настанд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний сүлжээ бий болгож, олон нийтийн оролцоог хангана.** | | | | | | | |
| БСТ 1.1.2.1 | 4. Ахмадын ЭМ-ийг дэмжих чиглэлээр ажилладаг ТББ-ын туршлага солилцох уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах | Улсын хэмжээнд тэмдэглэж заншсан. | Уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулагдаж, оролцогч талуудын оролцоог хангасан байна. | I-IV улирал | ЭШСА | Ахмадын ЭМ-ийг дэмжих чиглэлээр ажилладаг ТББ-ын туршлага солилцох уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулахаар удирдамж, төлөвлөгөө боловсруулан, ахмадын байгууллагуудаас санал авахаар албан бичиг хүргүүлэхээр боловсруулалтыг хангаж байна. | 10% |
| | 1. Эрүүл насжилтын үндэсний төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах | /-/ | Эрүүл насжилтын үндэсний төлөвлөгөөний 2025 оны арга хэмжээ 100% биелэсэн байна. | I-IV улирал | ЭШСА | Монгол улсын “Эрүүл насжилтын 10 жилийн үндэсний төлөвлөгөөний төслийг ЭШСА-наас 2024 онд боловсруулан ЭМЯ-нд хүргүүлсэн ба энэ оны эхний улиралд ДЭМБ-ын суурин төлөөлөгчийн газарын асуудал хариуцсан мэргэжилтэн болон, ГБХНХЯ-ныхолбогдох газар хэлтсийн төлөлөтэй хамтран хэлэлцэж, эцэслэн боловсруулаад ЭМЯ-нд хүргүүлсэн. ЭМЯ-наас төлөвлөгөө батлагдаж гараагүй байгаа тул хэрэгжилт эхлээгүй байна. | |
| БСТ 1.1.2.4 | 2. Ахмад настны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд ээлтэй орчин бүрдүүлэх чиглэлээр анхан шатлалын эрүүл мэндийн байгууллагуудад мэргэжил арга зүйн | 54 байгууллага | 60 байгууллага хамруулсан байна. | I-IV улирал | ЭТҮА | 2025 оны эхний хагас жилийн байдлаар Ахмад настны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд ээлтэй орчин бүрдүүлэх чиглэлээр анхан шатлалын 16 эрүүл мэндийн байгууллагуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.<br>Үүнд:<br>1. БЗд 9-р хорооны ӨЭМТ<br>2. Схд 3-р хорооны ӨЭМТ<br>3. Ахмад настны үндэсний төв. | |

| Д/д | Арга хэмжээ | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хэрэгжилтийн үйл явц | Биелэлт ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зөвлөгөө өгч ажиллана. | | | | | 4. Сэлэгэ аймгийн Мандал сум<br>5. Схд 3-р хороо ӨЭМТ<br>6. Схд 7-р хороо ӨЭМТ<br>7. Схд 16-р хороо ӨЭМТ<br>8. Схд 17-р хорооӨЭМТ<br>9. Багахангай дүүргийн ахмадын хороо<br>10. ХУД 22-р хороо ӨЭМТ<br>11. ХУД 9-р хороо ӨЭМТ<br>12. СХД 30-р хороо ӨЭМТ<br>13. СХД 15-р хороо ӨЭМТ<br>14. ЧД 22-р хороо ӨЭМТ<br>15. БЗД 34-р хороо ӨЭМТ<br>16. ХУД 14-р хороо ӨЭМТ мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч шалгуурын дагуу үнэлгээ хийсэн. | |
| БСТ 1.1.2.4 | 17. Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/23 дугаар тушаал “Гериатрийн кабинетийн үлгэрчилсэн дүрэм”-ийн хэрэгжилтийг хангахад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллана. | 8 байгууллагад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн. | 16 байгууллагад мэргэжил аргазүйн зөвлөгөө өгч ажиллана. | I-IV улирал | ЭТҮА | Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/23 дугаар тушаал “Гериатрийн кабинетийн үлгэрчилсэн дүрэм”-ийн хэрэгжилтийг хангахад мэргэжил арга зүйн дэмжлэгийг.<br>1. БЗд 9-р хорооныӨЭМТ<br>2. Схд 3-р хорооныӨЭМТ<br>3. Схд 3-р хороо ӨЭМТ<br>4. Схд 7-р хороо ӨЭМТ<br>5. Схд 16-р хороо ӨЭМТ<br>6. Схд 17-р хорооӨЭМТ<br>7. ХУД 22-р хороо ӨЭМТ<br>8. ХУД 9-р хороо ӨЭМТ<br>9. СХД 30-р хороо ӨЭМТ<br>10. СХД 15-р хороо ӨЭМТ<br>11. ЧД 22-хороо ӨЭМТ<br>12. БЗД 34-р хороо ӨЭМТ<br>13. ХУД 14-р хороо ӨЭМТ | |

| Д/д | Арга хэмжээ | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хэрэгжилтийн үйл явц | Биелэлт ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 3. Байгалийн гамшиг, нийтийг хамарсан өвчлөл, гэнэтийн аюул ослын асуудлыг шийдвэрлэх эрсдэлийн менежментийн чадавхийг бэхжүүлнэ. (ЗГҮАМХ)** | | | | | | | |
| БСТ 1.1.3.1 | 8. Геронтологийн үндэсний төвийн Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж батлуулан хэрэгжүүлнэ. | 2024 онд Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж, бэлэн байдлыг хангаж ажилласан. | Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж, бэлэн байдлыг хангаж, дадлага сургуулилтыг 2 удаа хийсэн байна. | I-IV улирал | ЗСТА | • Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний тодотгол хийсэн. /2025 он/ Томилгоожсон мэргэжлийн ангийн бүрэлдэхүүний гэрийн хаяг, утасны жагсаалт, бие холбоочин шинээр оруулж өгсөн.<br>• Газар хөдлөлтийн үеийн бэлэн байдлын албан бичгийн дагуу 1 удаагийн сургуулилт хийгдсэн.<br>• ЭМЯ-наас зохион байгуулсан гамшгаас хамгаалах бэлэн байдлын сургалтанд байгууллагаа төлөөлж 2 хүн хамрагдсан.<br>• 2026 оны гамшгаас хамгаалах үйл ажиллагааны зардлыг төсөвт суулгаж өгсөн. | |
| **Зорилт 4. Настны цогц тусламж, үйлчилгээг хөгжүүлэн, нутагшуулна.** | | | | | | | |
| БСТ 1.2.1.1 | 9. ДЭМБ-ийн боловсруулсан Ахмад настны цогц тусламж үйлчилгээний удирдамжийг өөрийн оронд тохируулан шинэчлэн боловсруулж хэрэгжүүлнэ. | ЭМЯ дээр Ахмад настны цогц тусламж, үйлчилгээний ажлын хэсэг байгуулагдаж 2024 оны 01 сарын А/22 дугаар тушаалаар “Ахмад настны цогц тусламж, үйлчилгээний заавар” батлагдсан | Геронтологийн үндэсний төвд “Ахмад настны цогц тусламж, үйлчилгээний заавар”-ыг хэрэгжүүлж 500 ахмад настанд тусламж, үйлчилгээ үзүүлсэн байна. | I-IV улирал | ЭТҮА | Эхний хагас жилийн байдлаар Гериатрын кабинет нь 1457 настанд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлснээс 213 настанд, настны цогц үнэлгээ хийж доройтлоос урьдчилан сэргийлэх зөвлөгөө өгч ЭМС-ын А/22-р тушаал-ын дагуу боловсруулсан “Ахмад настны цогц үнэлгээ Эрүүл насжилтын төлөвлөгөө” гарын авлага өгч, 89 настанд R онош буюу насны доройтол онош тавьж үр дүнг тооцож ажилласан. | |
| БСТ 1.2.1.2 | 10. Ахмад настны сэргээн засах эмчилгээний төрлийг нэмэгдүүлнэ. | Сэргээн засах, хөдөлмөрийн заслын тоног төхөөрөмжөөр хангасан. | Сэргээн засах эмчилгээний 2-3 тоног төхөөрөмжийг | IV улирал | ЭТҮА | Сэргээн засахын 2 төрлийн аппарат ашиглалтад оруулан ажиллаж байна. | |

| Д/д | Арга хэмжээ | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хэрэгжилтийн үйл явц | Биелэлт ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | ашиглалтад оруулсан байна. | | | 1. Bio Tron-DX тенс ict аппарат солонгос улсад үйлдвэрлэсэн. 2025.02.20 2 үйлдэлтэй 1 аппарат<br>2. STL-101 лазер эмчилгээний аппарат 2025.5.29 солонгос улсад үйлдвэрлэсэн.<br>  | |
| БСТ 1.2.1.3 | 11. Ахмад настанд үзүүлэх урт хугацааны тусламж, үйлчилгээний заавар, журам боловсруулна. | ЭМС-ын 2022 оны 10 сарын 1-ний А/511 тушаалаар “Урт хугацааны тусламж үйлчилгээний загвар боловсруулах” ажлын хэсэгт 2 мэргэжилтэн орсон. | Урт хугацааны тусламж, үйлчилгээний загварыг боловсруулахад чиг үүргийн хүрээнд оролцсон байна. | I-IV улирал | ЭТҮА | ЭМС-ын 2022 оны 10 сарын 1-ний А/511 тушаалаар “Урт хугацааны тусламж үйлчилгээний загвар боловсруулах” ажлын хэсэгт 2 мэргэжилтэн орсон | |
| БСТ 1.2.1.4 | 12. Ахмад настанд амбулаторийн болон хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ үзүүлнэ. | 2024 онд 28641 ахмад настанд амбулаториор эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэн ажилласан байна. | Амбулаторийн тусламж, үйлчилгээг 29000 хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээг 750 ахмад настанд үзүүлсэн байна. | I-IV улирал | ЭТҮА | 2025 оны эхний хагас жилийн байдлаар ахмад настанд амбулаторийн тусламж үйлчилгээг - 10972 настанд үзүүлсэн.<br>Өдрийн эмчилгээнд нийт-256 настанг хамруулсан. | |
| **Зорилт 5. Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг тасралтгүй хангаж, эрсдэлээс урьдчилан сэргийлнэ.** | | | | | | | |
| | 13. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, | 2024 онд Төвийн эрүүл мэндийн | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй | I-IV улирал | ЭМТҮЧАБА | 1. Чанарын алба нь төлөвлөсөн хуваарийн дагуу чанарын хяналт үнэлгээг | 92% |

| Д/д | Арга хэмжээ | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хэрэгжилтийн үйл явц | Биелэлт ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | аюулгүй байдлыг сайжруулах үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулна. | тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөөний хэрэгжилт 92.5 хувьтай хэрэгжсэн байна. | байдлыг сайжруулах төлөвлөгөөний хэрэгжилт 98.5 хувьтай хэрэгжсэн байна. | | | хийдэг. 2025 онд нийт 25 удаа хяналт хийж ажилласан.<br>2. Чанарын хяналт үнэлгээнд тусламж, үйлчилгээний чиглэлээр боловсруулсан 46 төрлийн хяналтын хуудаснуудыг ашиглаж байна.<br>3. Чанарын албанаас хийсэн хяналт үнэлгээний тайлантай.<br>4. Чанарын хяналт үнэлгээний дүгнэлтэд үндэслэн 9 ажлыг сайжруулах талаар зөвлөмж, шаардлагыг хүргүүлж, хэрэгжилтэд эргэн хяналт тавьсан.<br>5. Хяналт, үнэлгээний явцад илэрсэн асуудлыг хариуцсан албан тушаалтан болон удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулж, бүрэн шийдвэрлэж ажилласан. | |
| БСТ 1.2.3.2 | 14. “MNS 7014:2023 Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага”стандарт, Геронтологийн үндэсний төвийн нийтлэг үйлчилгээний журмын хэрэгжилтийг хангаж ажиллана. | Геронтологийн үндэсний төвийн нийтлэг үйлчилгээний журмын хэрэгжилт 92.5 хувьтай байна. | Геронтологийн үндэсний төвийн нийтлэг үйлчилгээний журмын хэрэгжилт 93.5 хувьтай болсон байна. | I-IV улирал | ЭМТҮЧАБА | 1.“MNS 7014:2023 Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага, стандарт”-ын хэрэгжилтийг хангах хүрээнд “Геронтологийн үндэсний төвийн эрүүл мэндийн үйлчилгээнд тавигдах журам” төвийн захирлын 2023 оны А/104 дугаар тушаалаар батлагдсан журмыг төвийн ажилтнуудад танилцуулж хэрэгжилтэд 3 удаа хяналт үнэлгээ хийсэн.<br>2. Үйлчлүүлэгчдэд мэдээлэл өгөх лавлагаа мэдээллийн хөтөч нь угтах үйлчилгээний хэсэгт “Угтах үйлчилгээний мэдээлэл өгөх батлагдсан журам”-ын дагуу мэдээллийг өгч ажиллаж байна<br>2. Амбулаторийн тусламж, үйлчилгээний үйл явц, дуугүй хөтөч болон зурагт хуудас, цахим дэлгэц, урсдаг гэрэлт самбараар | 91% |

| Д/д | Арга хэмжээ | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хэрэгжилтийн үйл явц | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өдөр тутмын мэдээ мэдээллээр хангаж ажиллаж байна.<br><br><br>3. Төвийн зохион байгуулалт, тусламж, үйлчилгээний чиглэлийн тэмдэг, тэмдэглэгээг үйлчлүүлэгчдэд ойлгомжтойгоор байршуулсан. | |
| | 15. Чанарын олон улсын удирдлагын тогтолцооны сайн туршлага судалж, үйл ажиллагаандаа нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна. | 3 сайн туршлага нэвтрүүлж ажилласан. | 3 сайн туршлага нэвтрүүлж ажилласан байна. | I-IV улирал | ЭМТҮЧАБА | Ижил төстэй эрүүл мэндийн байгууллагуудын шинэ технологи, сайн туршлагыг судалж, төвийн тусламж, үйлчилгээнд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. | 20% |
| БСТ 1.2.3.1 | 16. ОУ-н эмнэлзүйн платформын ашиглалтыг нэмэгдүүлж, хэрэгжилтэнд хяналт үнэлгээ хийнэ. | Up-To-Date платформын ашиглалтын аргачлалыг эмч мэргэжилтнүү-дийн 95 хувьд нь эзэмшүүлж, | Up-To-Date платформын ашиглалтын аргачлалыг эмч мэргэжилтнүү-дийн 95 хувьд нь эзэмшүүлж, хэрэглээнд нэвтрүүлсэн байна. | I-IV улирал | ЭМТҮЧАБА | ЭМТҮЧАБ-ыг сайжруулах, нотолгоонд суурилсан анагаах ухааны оношилгоо, эмчилгээнд ашиглах UpToDate цахим платформыг ашиглах цахим сургалтад төвийн нийт эмч, мэргэжилтнүүд хамрагдсан. | 20% |

| Д/д | Арга хэмжээ | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хэрэгжилтийн үйл явц | Биелэлт ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хэрэглээнд нэвтрүүлсэн байна. | | | | | |
| **Зорилт 6. Ахмад настны тусламж, үйлчилгээнд дэвшилтэд технологи нэвтрүүлнэ.** | | | | | | | |
| БСТ 1.2.4.1 | 17. Төвийн оношилгоо, эмчилгээний тоног төхөөрөмжийн хүчин чадал, нэр төрлийг нэмэгдүүлнэ. | /-/ | Хэт авиан оношилгооны суурин аппарат, сэргээн засахын орчин үеийн тоног төхөөрөмжүүдийг оношилгоо, эмчилгээндээ нэвтрүүлсэн байна. | III улирал | ЭТҮА, СААҮА | 2025 оны худалдан авах төлөвлөгөөгөөр батлуулсан эмнэлгийн тоног төхөөрөмж худалдан авах тендерээр хэт авиа оношилгооны суурин аппарат, сэргээн засахын лазер эмчилгээний аппарат, интерфероме трийн гүйдлийн төрлийн нам давтамжийн өдөөгч суурин зэрэг сүүлийн үеийн тоног төхөөрөмж худалдан авч эмчилгээ оношилгоондоо нэвтрүүлсэн.<br>1. Хэт авиан оношилгооны суурин аппарат 2023 9 сард Хятад улсад үйлдвэрлэгдсэн Mindray компани COMSONA N6<br>2. Сэргээн засахын орчин үеийн тоног төхөөрөмжүүдийг<br>3. Нүдний даралтны аппарат Хятад улсад үйлдвэрлэгдсэн 2024.07.30 үйлдвэрлэгдсэн SK-5000B загварын<br>4. Ясны сийрэгжилтйн зөөврийн Ultrasound Bone Densitobeter. OSTEOKJ3000 аппаратыг ашиглалтанд оруулан ажиллаж байна. | |

| Д/д | Арга хэмжээ | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хэрэгжилтийн үйл явц | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | |   | |
| БСТ 1.2.4.2 | 18. Эмнэлзүйн (гематологийн, биохимийн, иммунологийн, бактериологийн, шээсний анализатор) лабораторийн аппаратаар хангана. | /-/ | Биохимийн болон иммунологийн, бактериологийн лабораторийн аппаратаар хангасан байна. | III улирал | ЭТҮА, СААҮА | Эмнэлзүйн (гематологийн, биохимийн, иммунологийн, бактериологийн, шээсний анализатор) лабораторийн аппаратуудыг худалдан авсан шинэ эмнэлэгт орвол ашиглахад бэлэн байна. Өнөөдрийн байдлаар гэрээгээр гүйцэтгэж байгаа болно. | |
| **Зорилт 7. Геронтологи, гериатрийн чиглэлээр мэргэшсэн хүний нөөц бэлтгэх, мэргэшил, арга зүйгээр хангана.** | | | | | | | |
| БСТ 2.1.1.2 | 19. “Настан судлалын эмч”, “Настны сувилахуйн” мэргэшүүлэх сургалт зохион байгуулна. | 2024 онд Настны эмч 2, настны сувилагч 3-ыг бэлтгэсэн. | Нийслэлд 1, орон нутагт 1 настны эмч, сувилагч 2 нийт 4 мэргэжилтэн бэлтгэгдэсэн байна. | I-IV улирал | ЭШСА | 2024-2025 оны 1 дүгээр улиралд төгсөлтийн дараах төрөлжсөн мэргэшлийн “Настан судлал”-аар 7 эмч, “Настны сувилахуй”-аар 2 сувилагч элссэн бөгөөд сургалтын хөтөлбөрийн дагуу календарчилсан төлөвлөгөөг гарган сургалтыг зохион байгуулж байна. | 100% |
| БСТ 2.1.1.1 | 20. Геронтологийн үндэсний төвийн хүний нөөцийн хөгжлийн төлөвлөгөө 2023-2026 хэрэгжүүлнэ. | Хэрэгжилт 93 хувь биелсэн байна. | Хэрэгжилт 94 хувь биелсэн байна. | I-IV улирал | ЗСТА | Геронтологийн үндэсний төвийн хүний нөөцийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулж байгаа. | 30% |

| Д/д | Арга хэмжээ | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хэрэгжилтийн үйл явц | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| БСТ 2.1.1.3 | 21. Эмнэлгийн мэргэжилтнүүдэд настны эрүүл мэндийн чиглэлээр сэдэвчилсэн багц цагийн сургалт зохион байгуулна. | Нийслэлд 2 удаа 150 мэргэжилтэн, Хэнтий, Дорнод, аймагт 160, эмч мэргэжилтэн хамруулсан байна. | Нийслэлд 2 удаа 150 мэргэжилтэн, 2 аймагт орон нутагт танхимаар 160, эмч мэргэжилтэн, цахим сургалтад 160 эмч мэргэжилтнийг тус тус хамруулсан байна. | I-IV улирал | ЭШСА | Геронтологийн үндэсний төвийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу “Ахмад настанд үзүүлэх эрүүл мэндийн цогц тусламж, үйлчилгээ” сэдэвт багц цагийн сургалтыг зохион байгуулах еөрнхий захирлын тушаалаар удирдамж, төлөвлөгөөг батлуулан, 2025 оны 3-р сарын 27-ны өдөр нийслэлийн ӨЭМТ-ийн эмч , мэргэжилтнүүдийг оролцуулан, 2025 оны 4 дүгээр сарын 22 ноос 4 дүгээр сарын 30-ныг хүртэл Баруун бүсийн Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий, Увс зэрэг аймгуудад зохион байгууллаа. Сургалтаар ДЭМБ-ын 2021-2030 Эрүүл насжилтын төлөвлөгөө, “Ахмадын тухай” хуулийн шинэчилсэн найруулга зэрэг бодлогын баримт бичгийг танилцуулах, ЭМС-ын 2024 оны А/22 дугаар тушаалаар баталсан ‘Ахмад настны эрүүл мэндийн цогц тусламж үйлчилгээний заавар’-ыг хэрхэн хэрэгжүүлэх арга зүйн мэдлэг чадвар олгосон. Сургалтанд нийт 500 гаруй эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдав. | 100 |
| БСТ 2.1.1.4 | 22. Настан судлалын цахим болон танхимын хөтөлбөрийн боловсруулан батлуулж анагаах ухааны сургуулиудын хичээлийн болон өрхийн анагаах ухааны судлах | /-/ | Настан судлалын хичээлийн хөтөлбөр боловсруулан батлуулсан байна. | I-IV улирал | ЭШСА | Настан судлалын цахим болон танхимын хөтөлбөрийн боловсруулан, ЭМХТ-өөр батлуулан ЭМХТ-ийн HRDS програмд байршуулан, сургалтыг зохионбайгуулж байна. Настан судлалын агуулгыг анагаах ухааны сургуулиудын хичээлийн болон өрхийн анагаах ухааны судлах хичээлийн хөтөлбөрт оруулахаар судалж байна. | 70% |

| Д/д | Арга хэмжээ | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хэрэгжилтийн үйл явц | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хичээлийн хөтөлбөрт оруулна. | | | | | | |
| БСТ 2.1.1.5 | 23. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамж үйлчилгээнд настныг хамруулж буй настнуудын байгууллага, иргэн, аж ахуйн нэгжид ажиллаж буй мэргэжилтэнг мэргэшүүлж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангана. | Олон нийтийн ололцоонд түшиглэсэн халамж үйлчилгээний тендерийн магадлан итгэмжлэлийн ажлын хэсэгт мэргэшсэн гериатр эмчийг оруулж, ХХҮЕГ-тэй хамтран ажилласан байна. | Олон нийтийн ололцоонд түшиглэсэн халамж үйлчилгээний төрийн бус байгууллагуудын ажилтнуудын 25 хувийг сургасан байна. | I-IV улирал | ЭШСА | Олон нийтийн ололцоонд түшиглэсэн халамж үйлчилгээний төрийн бус байгууллагуудын ажилтнуудыг чадавхижуулах сургалтын хөтөлбөрийг боловсруулан, хамтран ажиллах байгууллагуудад хүргүүлэх бэлтгэл ажлыг хангаж байна. | 30% |
| **Зорилт 8. Байгууллагын хүний нөөцийн хөгжлийн тасралтгүй байдал, нийгмийн баталгааг хангана.** | | | | | | | |
| БСТ 2.1.2.1 | 24. Төвийн хөдөлмөрийн дотоод журам, ажлын үнэлгээний журмуудыг шинэчлэн боловрсуулж хэрэгжүүлсэн байна. | 2023 онд Төвийн хөдөлмөрийн дотоод журам, ур чадварын үнэлгээний журмыг шинэчлэн боловрсуулж хэрэгжүүлсэн. | Төвийн хөдөлмөрийн дотоод журам, ажлын үнэлгээний журмуудыг шинэчлэн боловрсуулж хэрэгжүүлсэн байна. | I улирал | ЗСТА | Төвийн хөдөлмөрийн дотоод журамыг 2025.02.26-ны өдрийн А/14 дугаар тушаалаар батлуулсан. | 50% |
| БСТ 2.1.2.2 | 25. Геронтологийн үндэсний төвийн бүтэц, орон тоотой уялдуулан 2025-2027 оны хүний нөөцийн төлөвлөлтийг хийнэ. | Хүний нөөцийн хангалт 94 хувьтай байна. | Хүний нөөцийн хангалт 96 хувьтай болсон байна. | I, II улирал | ЗСТА | Геронтологийн үндэсний төвийн бүтэц орон тоотой уялдуулан 05 сард бүтэц өөрчлөгдөж хасгас жилийн байдлаар хүний нөөцийн хангалт 93 хувьтай байна. | 90% |

| Д/д | Арга хэмжээ | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хэрэгжилтийн үйл явц | Биелэлт ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| БСТ 2.1.2.1 | 26. Байгууллагын ажилтнуудын харилцаа, хандлага, ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ. | Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хороо шинэчлэн батлагдсан. Төлөвлөгөөний хэрэгжилт 91 хувьтай байна. Ёс зүйн зөрчил гараагүй | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 92 хувьтай болсон байна. Ёс зүйн зөрчил гаргаагүй ажилласан байна. | I-IV улирал | ЗСТА | Төвийн дэргэдэх салбар хорооны 2025 оны үйл ажилгааны төлөвлөгөөний хэрэгжилт хагас жилийн байдлаар 50 хувьтай байна. Нийт ёс зүйн хороонд 5-н өргөдөл ирснээс 2- өргөдөл шийдвэрлэсэн.3-н өргөдөл хэлэлцэх хугацаандаа явж байна. | 50% |
| **Зорилт 9. Ахмад настны амьдралын чанарын судалгаа хийж, эрүүл насжилтийг дэмжинэ.** | | | | | | | |
| БСТ 2.2.1.1 | 27. Геронтологи, гериатрийн чиглэлээр эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулна. | “Эрүүл насжилтыг дэмжихүй” ЭШХ-ыг АШҮИС-ын НЭМС-тай хамтран зохион байгуулсан. | Геронтологийн Үндэсний төвийн 20 жилийн ойд зориулсан ЭШ, онол практикийн хурлыг зохион байгуулсан байна. | IV улирал | ЭШСА | - | - |
| БСТ 2.2.1.2 | 28. Настны эрүүл мэнд, нийгэм сэтгэлзүйн байдал үндэсний хэмжээний тойм судалгааг хийнэ. | Ахмад настны эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээний хэрэгцээ шаардлага, эрүүл мэндийн тогтолцооны бэлэн байдлыг үнэлэх, нотлогоо бүрдүүлэх чадавхийг үнэлэх судалгаа 2023 онд хийгдсэн. | Судалгааг эхлүүлсэн байна. | I-IV улирал | ЭШСА | Ахмад настны эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээний хэрэгцээ шаардлага, эрүүл мэндийн тогтолцооны бэлэн байдлыг үнэлэх, нотлогоо бүрдүүлэх чадавхийг үнэлэх зорилгоор судалгааны санал боловсруулан ДЭМБ-ын суурин төлөөлөгчийн газар хүргүүлээд байна. | 10% |
| БСТ 2.2.1.1 | 29. Насжилт, настны эрүүл мэнд сэтгүүлийг эрхлэн гаргана. | 2024 оны 1 дүгээр улиралд 7-р дугаар хэвлэгдэн гарсан. | Сэтгүүл хэвлэгдэж, байгууллагуудад түгээсэн байна. | IV улирал | ЭШСА | - | - |

| Д/д | Арга хэмжээ | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хэрэгжилтийн үйл явц | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| БСТ 3.1.1.3 | 30. Геронтологи, гериатрийн чиглэлээр олон улсын хурал зөвлөгөөн, сургалтад оролцоно. | БНСУ-ын улсын туршлага судалсан. | Азийн болон европын орнуудын туршлагыг судалж, хэрэгжүүлж эхэлсэн байна. | I-IV улирал | ЭШСА | ЭШСА-ны мэргэжилтэн С.Гантуяа Хонг-Конг улсад 2025 оны 5-р сарын 28-31-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “ Healthy ageing 2025” Ахмад настны цогц туламж, үйлчилгээг хэрэгжүүлж буй Монгол улсын туршлагыг танилцуулж, ICOPE-ийн шинэчилсэн сургалтад суралцсан. | 100% |
| **Зорилт 10. Байгууллагын хөгжил, бүтэц, зохион байгуулалтын оновчтойг тогтолцоог бүрдүүлнэ.** | | | | | | | |
| БСТ 3.1.1.4 | 31. Байгууллагын удирдлага, бүтэц, зохион байгуулалтын оновчтойг тогтолцоог бүрдүүлэх | /-/ | Төвийн шинэ эмнэлгийн бүтэц, зохион байгуулалтын дагуу албан тушаал, алба нэгжийн бүтэцийг шинэчлэн батлуулсан байна. | I-IV улирал | ЗСТА | Геронтологийн үндэсний төв нь шинэ эмнэлгийн байранд ороогүй.<br>ЭМЯ-нд 2026 онд шинэ эмнэлгийн бүтэц зохион байгуулалтыг 87-н ажилтнаар төлөвлөж 2026 оны төсөвт суулгуулсан. | 50% |
| БСТ 3.1.1.4 | 32. Төвийн цахим мэдээллийн аюулгүй байдалд үнэлгээ хийлгэж, эрсдлээс сэргийлэх арга хэмжээ зохион байгуулна | /-/ | Эрсдлээс сэргийлсэн 4 - 5 арга хэмжээ зохион байгуулсан байна. | I-IV улирал | ЗСТА | Төвийн цахим хуудасны бүтэц, агуулга, мэдээллийн баяжилтын байдалд Төрийн байгууллагын цахим хуудасны MNS6285:2017 стандарт, Мэдээллийн ил тод нээлттэй байдлын хэрэгжилтийг тайлагнах хүснэгт, Шинжилгээний чиглэл, шалгуур үзүүлэлтүүдийн шаардлагыг хэрхэн хангаж байгаад хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн. Үүний дагуу Шинэчлэлт хийхээр дараагын үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна. | |
| | 33. Төсөв санхүүгийн ил тод, нээлттэй байдлыг хангаж ажиллах, хяналт тавьж ажиллана. | Санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдал сайжирсан байна. | Санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдлыг сайжруулж шилэн данс холбогдох мэдээллийг хугацаанд нь, хугацааны хоцролгүй болно. | I-IV улирал | САAYA | Шилэн дансны тухай хуулийн дагуу санхүүгээс<br>• Сар бүр мэдээлдэг - 5<br>• Хагас жил бүр - 4<br>• Жил бүр - 7<br>Нийт 16 мэдээллийг хуулийн хугацаанд мэдээлж байна. Үүнд:<br>• Сар бүрийн мэдээлэлд хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга | |

| Д/д | Арга хэмжээ | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хэрэгжилтийн үйл явц | Биелэлт ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэмжээний гүйцэтгэл, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, зээл, , түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрүүд .<br>• Хагас жил бүр санхүүгийн тайлан, хандив, тусламжийн орлого, хандив, тусламжийн зарцуулалтын тайлан, өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан<br>Жил бүр санхүүгийн тайлан, хандив, тусламжийн зарцуулалтын тайлан, хандив, тусламжийн орлого, өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, концессын зүйлийн жагсаалт, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлангуудыг шилэн дансанд тус тус мэдээлж байна | |
| **Зорилт 11. Төвийн санхүүгийн төлөвлөлтийг шинэчлэн, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлнэ.** | | | | | | | |
| БСТ 3.1.2.1 | 34. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын чанар, төлбөрийн хяналт хийсэн нэхэмжлэлийн | Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын чанар, төлбөрийн хяналт хийсэн нэхэмжлэлийн | Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын чанар, төлбөрийн хяналт хийсэн нэхэмжлэлийн | I-IV улирал | ЗСТА | Геронтологийн үндэсний төвийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний даатгалын гүйцэтгэлийн чанарын хяналтаар эмнэлзүйн хасалт бүртгэгдээгүй. Цахим хасалтын хувь 2025 оны хагас жилийн байдлаар 0,02 хувь болж буурсан.байна. | |

| Д/д | Арга хэмжээ | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хэрэгжилтийн үйл явц | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хасагдлын шалтгааныг сар бүр хянан, дүгнэн, тохиолдлыг бууруулан ажиллана. | хасагдал 0,04 хувь байсан. | хасагдал 0,03 хувь болсон байна. | | | | |
| БСТ 3.1.2.2 | 35. Байгууллагын санхүүгийн удирдлагыг баримтлан, үр ашигтай хэрэгжүүлж өр, авлагагүй ажиллана. | 2024 оны жилийн эцсээр ЭМД-сангаас 158,4 сая төгрөгийн авлагатай. Эндээс шалтгаалан тендерийн худалдан авалтын өглөг 76,0 сая төгрөг байна. | Төвийн төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй ажилласан байна. | I-IV улирал | САAУA | 2025 оны эхний хагас жилийн байдлаар ЭМД-ийн сангаас 65,2 сая төгрөгийн авлагатай байна. Тендерийн баталгааны өглөг 43,6 сая төгрөг, бараа ажил үйлчилгээний өглөг 2,1 сая төгрөг, хувь хүний орлогын албан татварын өглөг 9,9 сая төгрөг байна. | |
| БСТ 3.1.2.2 | 36. Байгууллагын тусламж, үйлчилгээний өртөг тооцож, холбогдох байгууллагад санал хүргүүлж ажиллана. | 2025 оны төсвийн төсөлд шинэ эмнэлэгт нэмэгдэх тусламж, үйлчилгээний өртгийн тооцооллыг хийж ЭМЯ-нд хүргүүлсэн. | 2026 оны шинэ эмнэлэгт нэмэгдэх тусламж, үйлчилгээний өртгийн тооцооллыг хийж холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна. | II улиралд | САAУA | Одоогийн байдлаар эрүүл мэндийн даатгалын газраас 10 төрлийн 700 оношийн хамааралтай бүлгээр ангилан нэг өвчтөнд ноогдох өртгийн жинг тооцоон санхүүжилт олгож байна. Манай байгууллагын хувьд шинэ эмнэлэгт орох үед одоогийн үзүүлж буй эмнэлгийн тусламж үйлчилгээний нэр төрөл нэмэгдэх боловч шинээр өртгийн тооцоолол хийж санал оруулах эмнэлгийн тусламж үйлчилгээ байхгүй байна. | |